



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 он



АГУУЛГА

02

Товчилсон үгийн тайлбар

03

Удирдлага, зохион байгуулалт

05

Санхүүгийн тайлангийн аудит

07

Гүйцэтгэлийн аудит

08

Нийцлийн аудит

08

ИТХ-ын захиалга болон өөрийн төлөвлөгөө хөтөлбөрөөр хийсэн аудит

08

Дотоод ажил

19

Төсвийн гүйцэтгэл, тайлагнал

19

Дүгнэлт, санал

20

Хавсралтууд



**Товчилсон үгийн тайлбар:**

АТГ	Авлигатай тэмцэх газар
БНШК	Баримт бичиг нягтлан шалгах комисс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗУГ	Захиргаа удирдлагын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СУГ	Стратегийн удирдлагын газар
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СХОГ	Санхүү хөрөнгө оруулалтын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭДТДҮТ	Тариалан эрхлэлтийг дэмжих техник дундын үйлчилгээний төв
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХШҮДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар

Монгол улсын Ерөнхий аудиторовын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/235 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан болон статистик мэдээг боловсруулж, тайлагнах журам”-ын дагуу Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны үйл ажиллагааг нэгтгэн, тайлагнаж байна.

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Ерөнхий зүйл: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, төрийн аудитын байгууллагын “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” үндсэн зорилт, төрийн аудитын системийн болон тус газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн, төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.



Тус газар нь Ерөнхий аудиторовын 2021 оны А/19 дүгээр тушаалаар баталсан бүтэц, орон тоогоор буюу 12 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд Ерөнхий аудиторовын 2021 оны Б/11 дүгээр тушаалаар Т.Мөнхзул тус газрын аудитораар томилогдсон.

2021 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитад туслах 3 гэрээт ажилтныг 9 сарын /давхардсан тоогоор/ хугацаатайгаар авч ажиллуулсан бол байгууллагын нягтлан бодох бүртгэл, бичиг хэргийн ажил үүргийг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлж ирлээ.

2021 онд хуанлийн 249 ажлын өдөр буюу 2988 хүн/өдөр ажиллахаас аудитын ачааллаас шалтгаалан нийт 260 өдөр, 3120 хүн/өдөр ажиллаж, 11 өдөр буюу 132 хүн/өдөр илүү ажилласан байна.

1.2 Төрийн аудитын байгууллагын 2021 оны “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх” үндсэн зорилтын хүрээнд хийсэн ажлууд:

ҮАГ-ын холбогдох газруудаас өгсөн чиглэлийн дагуу аудит болон үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Шилэн дансны нэгтгэлийн системд 298 байгууллагын мэдээллийг бүрэн оруулсан,
- Статистик мэдээний нэгтгэлийн системд 2020 оны жилийн эцэс, 2021 оны хагас жил болон жилийн эцсийн статистик мэдээг оруулсан,
- Төрийн аудитын сургалт, хөгжлийн системийн Е-хичээлийн сангийн 5 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 27 албан хаагч хамрагдаж, явцын шалгалтыг тухай бүр өгч ирлээ,



- TEAMS программыг ашиглан ҮАГ-ын Аудитын гуравдугаар газрын аудитын менежер, аудиторудтай аудитын үе шатны ажил, мэдээллийг харилцан солилцож байна,
- Хүний нөөцийн системд албан хаагчдын мэдээллийг бүрэн оруулсан,
- Санхүүгийн тайлангийн аудитын FAS системд аудитын хуваарийг оруулан, төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж байна,
- ABLE системийг ашиглан бусад нэгжүүдтэй мэдээлэл солилцож байгаа ба ирсэн, явсан бичиг, хүсэлт, өргөдөл гомдлыг тухай бүр бүртгэж, дарга, тэргүүлэх аудиторовын 2016-2021 оны тушаалуудыг цахимжуулж, архивлан хадгалсан болно,
- ZOOM, TEAMS программаар ҮАГ-ын удирдлагууд болон бусад бүтцийн нэгжүүдээс зохион байгуулсан цахим сургалт, хурал, семинарт тогтмол оролцож хэвшсэн байна.

1.3 Хийж гүйцэтгэсэн аудитууд, илрүүлсэн зөрчил, түүний шийдвэрлэлт:

Тайлант хугацаанд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрх болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтын хүрээнд 298 байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 5, аймгийн ИТХ-ын захиалга болон өөрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 3 зэрэг нийт 8 гүйцэтгэлийн аудит хийж гүйцэтгэлээ.

Нийт 70 байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэхээр хараат бус аудитын 4 компанитай гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн бол МУ-ын Ерөнхий аудиторовын 2020 оны “Журам батлах тухай” А/82 дугаар тушаалын дагуу 85 байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, хараат бус аудитын 5 компанитай гэрээ байгуулан, завсрын аудитыг эхлүүлээд байна.

2021 онд хийж гүйцэтгэсэн аудитиудаар нийт 863 төрлийн 26,283.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс бүртгэл тайлагналтай холбоотой 8,001.2 сая төгрөгийн алдааг залруулж, 192.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 16,075.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 2,005.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлэн, 7.7 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулаагүй 1 албан тушаалтныг хууль, хяналтын байгууллагад шилжүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан, төлбөрийн актыг барагдуулаагүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн их хэмжээний материаллаг зөрчил гаргасан зэрэг нийт 20 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

2021 онд хийж гүйцэтгэсэн аудитиудын дүнгээр нийт 11,868.7 сая төгрөгийн аудитын үр өгөөжийг бүртгэн, харилцагчид хүлээн зөвшөөрснөөр төсвийн зардлын 1 төгрөгт ногдох үр өгөөж 26.2 төгрөгт хүрсэн байна.


**1.4 Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:**

2021 онд хийж гүйцэтгэсэн аудитуудаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг объект дээр хүрч, тулган баталгаажуулснаар 180.6 сая төгрөгийн акт, 14,041.8 сая төгрөгийн албан шаардлагыг биелүүлсэн тоо мэдээтэй тайлагнагдаж байна.

ГРАФИК №1 /сая төгрөг/

2020 оноос шилжин ирсэн акт, албан шаардлагын дүнг нэгтгэн авч үзвэл тайлант онд нийт 195.7 сая төгрөгийн акт, 17,439.1 сая төгрөгийн албан шаардлагын хэрэгжилтийг ханган, акт 94.1 хувийн, албан шаардлага 89.6 хувийн, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага 100 хувийн биелэлттэй тайлагнагдлаа.

2021 онд хийж гүйцэтгэсэн аудитуудын дүнд бүртгэл тайлагналтай холбоотой 156, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 137, дотоод хяналтыг сайжруулах 73, бусад чиглэлээр 26, арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 8 гэх мэтчилэн нийт 400 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсний 85.8 хувь нь биелэгдсэн байна.

ГРАФИК №2**ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Санхүүгийн тайлангийн аудитад нийт 298 байгууллага, аж ахуйн нэгжийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хамруулахаар төлөвлөснөөс өөрийн аудиторуудаар 228, хараат бус аудитын 4 компаниар 70 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 11 хүн 538 хүн өдөр ажиллан, ажлын ачааллаас шалтгаалан 528 цаг илүү ажиллалаа.

Аудитад хамрагдсан 298 санхүүгийн тайлангаас 156 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 142 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргасан байна.

Нийт дүгнэлт гаргасан байгууллагын 118-д нь “Зөрчилгүй”, 22-д нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн бол Шаамар сумын ТТЗ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Сөрөг” дүгнэлт өгч, “ТЭДТДҮТ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.


Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 760 төрлийн 15,020.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,001.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан,



192.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 5,368.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 1,449.4 сая төгрөгийн зөрчилд 324 зүйлийн зөвлөмж өгч, 7.7 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулаагүй 1 албан тушаалтныг хууль хяналтын байгууллагад шилжүүлээд байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан, төлбөрийн актыг барагдуулаагүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд их хэмжээний материаллаг зөрчил гаргасан зэрэг 20 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээ.

ГРАФИК №3 /сая төгрөг/



Актын биелэлт: Өмнөх оны үлдэгдлээс 4.1 сая төгрөг, тайлант онд тогтоогдсон актаас 180.6 сая төгрөгийг төлүүлснээр актын биелэлт 94.1 хувьтай тайлагнагдсан бөгөөд 12.3 сая төгрөгийн төлбөр дараа онд шилжээд байна.

Албан шаардлагын биелэлт: Тайлант хугацаанд нийт 5,368.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлснээс өмнөх оны үлдэгдлээс 337.1 сая төгрөгийн, тайлант хугацааны 4,585.4 сая төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангуулж, 86.3 хувийн хэрэгжилттэй тайлагнагдсан бөгөөд сахилгын шийтгэл ногдуулах 20 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.

Зөвлөмжийн хэрэгжилт: Аудитаар арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах 8, бүртгэл тайлагналтай холбоотой 152, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 107, дотоод хяналтыг сайжруулах 47, бусад 10 зэрэг нийт 324 зөвлөмж өгснөөс 88.6 хувь болох 287-г нь хэрэгжүүлсэн байна.

Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал: 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндэслэлгүйгээр буцалтгүй тэтгэмж олгосон 7.7 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулаагүй 1 албан тушаалтныг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, хянуулж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,665.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагчаар хүлээн зөвшөөрүүлсэн ба аудитын бүх үе шатны ажлыг СТАУС программаар гүйцэтгэв.

Тус газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитад холбогдох хууль, стандарт, гарын авлагаас гадна "Төрийн аудитын байгууллагаас 2019-2020 онд санхүүгийн тайлангийн аудит



хийх ерөнхий чиглэл"-ийг удирдлага болгон, хэрэгжилтийг ҮАГ-ын Аудитын нэгдүгээр газарт тайлагналаа. Үүнд:

- Аудитын үе шатны ажлыг хангалттай, зохистой нотлох баримтаар баталгаажуулж, аудитын төгсгөлд эмхэтгэн архивлав.
- Аудитын бүх үе шатны ажлуудад стандарт, журмын дагуу чанарын хяналтыг хэрэгжүүлж, холбогдох маягтаар баримтжуулав.
- Санхүүгийн тайлангийн аудитыг төсвийн орлого бүрдүүлэх, зардал бууруулах санал бэлтгэх ажилтай уялдуулан орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг судлан, нормативт зардлуудын гүйцэтгэлд дүн шинжилгээ, судалгаа хийж, баримтжуулав.
- Уг аудитын хүрээнд Санхүүгийн аудитын газраас ирүүлсэн судалгааг маягт, хүснэгтийн дагуу гаргаж нэгтгүүлэв.
- Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, стандартын дагуу хөтөлж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөв.
- Аудитын зөвлөмжийн чанар, үр нөлөөг сайжруулах, стандартад нийцүүлэх чиглэлээр аудиторруудад заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг хангууллаа.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

2021 онд ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр 5, аймгийн ИТХ-ын захиалга болон өөрийн төлөвлөгөө хөтөлбөрөөр 3, нийт 8 гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрөөр:

- Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулах зардлын гүйцэтгэл,
- Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн,
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө,
- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт,

Аймгийн ИТХ-ын захиалга болон өөрийн санаачилгаар:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө,
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны зарцуулалт, үр дүн,
- Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг,

Гүйцэтгэлийн аудитын дүнг нэгтгэн авч үзвэл:

Албан шаардлагын биелэлт: Урьд оноос шилжиж ирсэн 605.8 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн биелүүлсэн бөгөөд тайлант хугацаанд өгөгдсөн 10,706.7 сая төгрөгийн албан шаардлагаас 9,456.4 сая төгрөг буюу 88.3 хувийг нь хэрэгжүүлэн, 1,250.3 сая төгрөгийн албан шаардлага дараа онд шилжээд байна.



Зөвлөмжийн хэрэгжилт: Өмнөх оны үлдэгдэл 9, тайлант оны 76 зэрэг нийт 85 зөвлөмжөөс 65 зөвлөмж буюу 76.5 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар 2,203.1 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцож, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

ДӨРӨВ. НИЙЦЛИЙН АУДИТ

Тайлант хугацаанд нийцлийн аудит төлөвлөгдөөгүй бөгөөд өмнөх оны статистик мэдээ тайланд тусгагдаагүй, он дамжиж хийгдсэн “*Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан*”-д хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, 288 нэр дэвшигчийн хууль, эрх зүйн актын шаардлага хангаагүй 93.5 сая төгрөгийн хандивын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт:

Өмнөх оноос шилжиж ирсэн 11.0 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 2,454.4 сая төгрөгийн албан шаардлага, 11 зөвлөмжийг хэрэгжүүлээд байна.

ТАВ. АЙМГИЙН ИТХ-ЫН ХҮСЭЛТЭЭР БОЛОН ӨӨРИЙН САНААЧИЛГААР ХИЙСЭН АУДИТ

Тус газар нь 2021 онд аймгийн ИТХ-ын захиалга, өөрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөгдсөн “*Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө*”, “*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны зарцуулалт, үр дүн*”, “*Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг*” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудыг хийж гүйцэтгэн, дүн, тайланг аймгийн ИТХ болон шалгагдагч байгууллагуудад хүргүүлэв.

Дээрх аудитуудаар нийт 8,441.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 25 албан шаардлага, 37 зөвлөмжийг хүргүүлэн, албан шаардлагын биелэлт 85.2 хувьтай, зөвлөмжийн биелэлт 91.9 хувьтай тайлагнагдлаа.

ЗУРГАА. ДОТООД АЖИЛ

2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг дэмжих дотоод ажлын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

6.1 МУ-ын Ерөнхий аудитор болон бусад удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт.

МУ-ын Ерөнхий аудитор, бусад удирдлагуудаас өгсөн дараах үүрэг, чиглэлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, тайлагнав. Үүнд:

- МУ-ын Ерөнхий аудиторовын 2021 онд гарсан 19 ширхэг “А” тушаалыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийн тайланг гаргаж, УАГ-ын ЗУГ болон ХШҮДАГ-т тогтоосон хугацаанд нь хүргүүлэв. / Тус газрын 2021 оны гүйцэтгэлийн тайланд тодорхой тусгасан /



- МУЕА-ын орлогчийн 2021 оны 01/450 дугаар албан бичгийн дагуу 2020 оны санхүүгийн тайланд нь “Итгэл үзүүлсэн” 30 байгууллагад албан бичиг хүргүүлээ.
- Тамгын даргын 2021 оны 03/1349, 03/1395 дугаар албан бичгүүдийн дагуу албан хаагчдын судалгаа, 14 хоногийн ажлын тайлан, хийх ажлын төлөвлөгөөг тогтоосон хугацаанд нь гаргаж, хүргүүлэв.
- СУГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2020 онд бичигдсэн 110 төлбөрийн акт, 233 албан шаардлагыг хуулбарлан хүргүүлсэн.
- ЗУГ-ын 2021 оны 04/08 дугаар албан бичгийн дагуу албан хаагчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, өрөө тасалгаанд 7-14 хоногт ариутгал хийж, албан хаагчдыг маск, дархлаа дэмжих витаминаар хангахад дэмжлэг үзүүлэв.
- ЗУГ-ын 2021 оны 04/1240 дугаар албан бичгийн дагуу 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр улирлын хэрэгжилтийн тайланг гаргаж 2021 оны 62 дугаар, 2021 оны 04/176 дугаар албан бичгийн дагуу Ерөнхий аудиторын 2020, 2021 оны "А" тушаалуудын хэрэгжилт, үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж 2021 оны 88 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.
- ХШҮДАГ-ын 2021 оны 10/158 албан бичгийн дагуу зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг гаргаж 2021 оны 82 дугаар албан бичгээр, 10/180 дугаар албан бичгийн дагуу 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хавсралт хүснэгтээр гаргаж 06 сарын 08-ны өдөр файлаар, МУ-ын Ерөнхий аудиторын 2020-2021 оны "А" тушаалуудын хэрэгжилтийн тайланг гаргаж 2021 оны 54, 57 дугаар албан бичгээр тус тус хүргүүлэв.
- Аудитын 1 дүгээр газрын 2021 оны 06/1192 дугаар албан бичгийн дагуу орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж 2021 оны 60 дугаар, 06/131 дүгээр албан бичгийн дагуу 2020 оны санхүүгийн тайланд хийх аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хэрэгжилтийн тайлан, холбогдох судалгааг 2021 оны 72 дугаар, 2022 онд санхүүгийн тайлангийн аудит хийх хэлбэрийн судалгаа, өөрчлөлт орсон байгууллагын судалгааг гаргаж 2021 оны 94 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлсэн.
- ҮАГ-ын Тамгын даргын өгсөн үүрэг даалгавар, баталсан хуваарийн хүрээнд тус газрын 2021 оны эхний 11 сарын үйл ажиллагааны тайлан, мэдээллийг 5 бүтэц, агуулгын хүрээнд Power Point программаар бэлтгэж, 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хуралдсан аймгийн Төрийн аудитын газрын удирдлагуудын цахим шуурхай хуралдаанд мэдээллээ.
- Ерөнхий аудиторын орлогчийн өгсөн үүргийн дагуу “Харилцагч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан”-г 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Харилцаа хамтын ажиллагааны газарт хүргүүлсэн.
- ҮАГ-ын удирдлагуудаас гаргасан шийдвэрийн дагуу Аудит цахим сэтгүүлд оруулах мэдээллийн хүрээнд тус газраас 2021 онд хийж хэрэгжүүлсэн шинэлэг санаа, сайн туршлагын талаарх мэдээллийг бэлтгэн, 2021 оны 12 дугаар 01-ний өдөр Харилцаа хамтын ажиллагааны газарт хүргүүлэв.

Эдгээрээс гадна ҮАГ-ын бүтцийн нэгжүүдээс зохион байгуулсан цахим уулзалтад тухай бүр оролцож, өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа.

6.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон "ТАБ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилт, байгууллагын ил тод байдал.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон "ТАБ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх, байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Төрийн тусгай 11 албан хаагч нь 2020 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж, мэдээлэв.
- Аудит эхлэхийн өмнө "Нөлөөллийн мэдүүлэг"-ийн талаар шалгагдагч байгууллагад танилцуулж, баталгаажуулж хэвшсэн бөгөөд аудитын үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлөөс ангид гүйцэтгэж ирлээ.
- Байгууллагын үйл ажиллагаа, хийж гүйцэтгэсэн аудитуудаар илрүүлсэн алдаа зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаар Сэлэнгэ аймгийн "Өргөн Сэлэнгэ" сэтгүүлд дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа ярилцлага өгсөн нь тайлант оны 3 дугаар сард хэвлэгдсэн байна.
- Хийж гүйцэтгэсэн аудитын тайланг нийтэд ил тод мэдээлэх зорилгоор аймаг, сумдын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан, хандив өгсөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн жагсаалт болон 158 байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, 5 гүйцэтгэлийн аудитын тайлан, дүнг audit.mn цахим хуудсанд байршуулав.
- 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, "Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын дүн, илрүүлсэн алдаа, зөрчлийн талаар 2 удаагийн видео танилцуулга /видео шторк/, өөрийн төлөвлөгөө, хөтөлбөрөөр хийж гүйцэтгэсэн 2 гүйцэтгэлийн аудитын тайлан, үр дүнгээр инфографик бэлтгэж, тус газрын фейсбүүк хуудсаар олон нийтэд түгээн, audit.mn сайтад байршуулсан.
- Хүний нөөцийн ил тод байдлыг хангах зорилгоор бүх албан хаагчдын хариуцсан ажил, үүрэг чиглэлийн талаарх мэдээлэл, ёс зүйн дүрэм болон авлигын эсрэг мэдээлэн сурталчлах материалыг байгууллагын мэдээллийн самбарт байршуулав.
- Төсвийн ил тод, нээлттэй зарчмын хүрээнд байгууллагын сар бүрийн төсвийн орлого, түүний зарцуулалт болон холбогдох бусад мэдээллийг мэдээллийн самбарт байршуулахаас гадна шилэн дансны цахим санд нийт 141 мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлэв.



6.3. Харилцаа, хамтын ажиллагаа, өргөдөл гомдол шийдвэрлэлт:

Тус газар нь 2021 онд “Харилцагч талуудын оролцооны болон иргэдийн оролцоог хангах стратеги төлөвлөгөө” боловсруулан харилцагч талуудтай дараах чиглэлээр хамтран ажиллалаа.

АИТХ, Засаг дарга

- Аудитын сэдвийн санал авах, саналын дагуу аудит хийх.
- ИТХ-ын хуралдаанд мэдээлэл, санал оруулж хэлэлцүүлэх, харилцан хамтын ажиллагааны талаар санал солилцох
- Аудитын тайлан хүргүүлэх, зөвлөмж өгөх гэх мэт

Шалгагдагч байгууллага

- Хийж гүйцэтгэх аудитын талаар мэдээлэл өгөх, аудитын тайлангийн төсөлд санал авах.
- Аудитын тайлан, дүнг хүргүүлэх, үр дүнг үнэлэх гэх мэт

Иргэд, олон нийт

- Аудитын сэдвийн болон гүйцэтгэж буй аудиттай холбогдох саналыг цахимаар авах.
- Ирүүлсэн өргөдөл, гомдолд хуулийн хугацаанд хариу хүргүүлэх.
- Сонирхсон аудитын тайланг хүргүүлэх гэх мэт

Хууль, хяналтын байгууллага

- Аудитаар илэрсэн гэмт хэргийн шинж чанартай байж болзошгүй зөрчлийг хүргүүлж, шийдвэрлүүлэх,
- Ирүүлсэн хүсэлтийн дагуу аудитын тайлан болон холбогдох баримт, материалыг хүргүүлэх гэх мэт

Дээрх байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

6.3.1 Аймгийн ИТХ, Засаг даргатай хамтран ажиллах талаар

- Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, үр дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж, хэлэлцүүлэв.



- Аймгийн ТЕЗ-аас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломжийн талаар 4, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр 5 зүйлийн санал, дүгнэлт боловсруулж аймгийн ИТХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлсэн.
- Аймгийн ИТХ-аас ирэх 2022 онд гүйцэтгэх гүйцэтгэлийн аудитын сэдвийн саналыг авч, МУ-ын Ерөнхий аудиторор батлуулахаар хүргүүлсэн.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ИТХ-ын зүгээс хийж гүйцэтгэх хяналт, шалгалтын талаар аймгийн ИТХ-ын даргад зөвлөмж өгч, харилцан санал солилцов.

- Аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран 2020 оны ИТХ-ын сонгуулийн үр дүнгээр сонгогдсон сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт Төрийн аудитын тухай хууль болон төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, тус газраас орон нутгийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны үйл ажиллагаа, үр дүнд хийж гүйцэтгэсэн аудитын дүнгийн талаар цахим танилцуулга хийж, мэдээлэл өглөө.
- Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд хийж гүйцэтгэсэн 8 гүйцэтгэлийн аудитын болон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүнг аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргад тус тус хүргүүлж, холбогдох зөвлөмж өгөө.

6.3.2 .Шалгагдагч байгууллагуудтай хамтран ажиллах талаар

- Тухай бүр хийж гүйцэтгэх аудитын нээлтийн мэдээлэл өгч, 2020 оны санхүүгийн тайланд хийж гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын 142 тайлан, дүгнэлт болон гүйцэтгэлийн аудитын 8 тайланг хүргүүлж, зөвлөмж өгөө.



- Албан томилолтоор 15 сум 5 тосгонд хүрч ажилласан бөгөөд дээрх сумдын 287 байгууллагын бүх шатны төсвийн захирагчдад 2021 онд хийж гүйцэтгэсэн аудитын дүн, 2022 оны СТА-аар анхаарах асуудлаар мэдээлэл хүргэж, акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тулган баталгаажуулав.

Орон нутагт хүрч ажиллан өмнөх аудитиудаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцсон болон төсөв, санхүүгийн холбогдолтой шинээр гарсан хууль эрхийн актуудыг танилцуулж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах чиглэлээр зөвлөмж өгсөн нь шалгагдагч байгууллагуудын талархлыг хүлээсэн арга хэмжээ боллоо.





➤ Боловсрол, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудад 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүн, илэрсэн алдаа, зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар цахимаар мэдээлэл, зөвлөмж өгөв.

6.3.3. Иргэд, олон нийттэй хамтран ажиллах талаар.

- Өмч хувьчлал, худалдан авах ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, цалин хөлс олголттой холбогдуулан Алтанбулаг, Сүхбаатар, Баянгол сумдын иргэдээс ирүүлсэн 5 удаагийн өргөдөлд дурдагдсан асуудлуудыг холбогдох баримт, материалуудтай нь тулган баталгаажуулж, хуулийн хугацаанд хариу хүргүүлэв.
- 2022 онд хийж гүйцэтгэх гүйцэтгэлийн аудитын саналыг иргэдээс цахимаар авах зорилгоор тус газрын фейсбүүк хуудсаар зар хүргүүлсэн гэх мэт.

6.3.4. Хууль, хяналтын байгууллагуудтай хамтран ажилласан талаар

АТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу дараах аудитын тайлан болон холбогдох баримт материалыг тулган баталгаажуулж, хариу хүргүүлэв. Үүнд:

- Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвтэй холбогдох төсөв, санхүүгийн асуудлыг тулган баталгаажуулсан дүн.
- Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүн,
- Шаамар сумын Дулаанхан тосгоны цэцэрлэгийн 2017-2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан болон холбогдох баримт, материалууд,
- 2020 онд хийж гүйцэтгэсэн “Аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан, Орхонтуул сумтай холбогдох баримт, материалууд гэх мэт.

Мөн тайлант онд тавигдсан 7.7 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулаагүй 1 албан тушаалтныг Мандал сум дахь Прокурорын газарт шилжүүлээд байна.

6.4 Сургалт, семинар:

ҮАГ-ын сургалтын төлөвлөгөө болон өөрийн аудитуудаас авсан санал хүсэлт, судалгааг үндэслэн тус газраас 2021 онд хийж гүйцэтгэх дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, мөрдөж, дараах сургалтуудыг зохион байгуулснаар аудитуудын мэргэжлийн мэдлэг, хийж гүйцэтгэж буй аудитын чанар, үр дүн тодорхой хэмжээгээр нэмэгдсэн гэж үзэж байна.

**6.4.1 ҮАГ-аас зохион байгуулсан цахим сургалт, семинар:**

- “Төрийн аудитын байгууллагын мэдээллийн нэгдсэн систем, нэвтрүүлэлт” сэдэвт онлайн сургалтад дарга, тэргүүлэх аудитор, аудитын менежер, мэдээлэл технологи хариуцсан ажилтан нар.
- Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны цахим семинарт дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа.
- Шилэн дансны нэгтгэлийн системд мэдээлэл оруулах сургалтад бүх албан хаагчид.
- Статистик мэдээний нэгтгэлийн системд мэдээлэл оруулах сургалтад бүх албан хаагчид.
- “ТАБ-аас аудит хийх журам”, “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”, “ТАБ-ын албан хаагчдын мөрдөх ёс зүйн журам”-ыг танилцуулах сургалтад бүх албан хаагчид.
- “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлалыг аудитын ажиллагаанд ашиглах арга зүй” сэдэвт сургалтад бүх албан хаагчид
- “Үр өгөөжийг тооцоолох, бүртгэх, тайлагнах журам”-ын сургалтад бүх албан хаагчид.
- “Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн сургалтын системийн ашиглалт” сургалтад 4 албан хаагч.
- “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг” сургалтад 4 албан хаагч,
- “Аудит хийх явцад илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах нь” сэдвээр зохион байгуулсан цахим сургалтад 4 албан хаагч,
- “Аудитын үйл ажиллагаанд захиргааны ерөнхий хуулийг хэрэглэх нь” сургалтад бүх албан хаагч,
- “Санхүүгийн тайлангийн мэдээллийн систем”-ийн сургалтад бүх албан хаагчид,
- “Гүйцэтгэлийн аудитын тайлагналын чанарт анхаарах нь” сэдэвт хэлэлцүүлэгт бүх албан хаагчид,

6.4.2. Төрийн аудитын байгууллагын “Сургалт хөгжлийн системийн Е-хичээл”-ийн сангийн сургалт:

- “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ” сургалтад 4 аудитор хамрагдаж, үе шатны шалгалтуудыг өгөв.
- Шинэ ажилтнуудад зориулсан “Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтад шинээр томилогдсон аудитор Т. Мөнхзул хамрагдаж, явцын шалгалтуудад хамрагдав.
- Архив, албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй болон монгол хэлний албан бичгийн найруулга, зөв бичих зүйн талаарх “Төрийн албан хэрэг хөтлөлт” сургалтад 9 албан хаагч.
- “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо” сэдэвт сургалтад дарга тэргүүлэх аудитор, аудитын менежер нар.
- “Эдийн засгийн бодлогын шинжилгээ” цахим хичээлд бүх албан хаагчид хамрагдаж, явцын шалгалтад хамрагдсан байна.

6.4.3. Өөрийн сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалт:

- 2021 оноос эхлэн шинээр мөрдөгдөж байгаа хуулиуд, төсөв, санхүү, бүртгэл хөтлөлттэй холбоотой Засгийн газрын тогтоол, холбогдох сайдын тушаалууд.
- Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлж байсан алдаа, зөрчил түүний шийдвэрлэлт, тайлант оны санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, алдаа зөрчлийн шийдвэрлэлт.
- Санхүүгийн тайлангийн аудитын тайлан, санал дүгнэлтийн хэлбэрийн шинэчилсэн загвар.
- Ерөнхий аудиторын 2021 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Акт, албан шаардлагын журам".



- Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программ хангамж, түүнийг аудитад ашиглах нь.
- Аудитын тайлан, дүнг олон нийтэд цахимаар хүргэх арга зам, инфографик, видео мэдээлэл ашиглаж мэдээлэл бэлтгэх нь.

- Шинээр томилогдсон 2 аудиторт СТАУС программыг хэрэглэх ажлын байран дахь сургалт.
- "Санхүүгийн аудитын тулгуур зарчим"
- Төрийн аудитын стандарт, аудитын үе шатны ажлуудын талаарх шат дараалсан 5 удаагийн сургалт,
- Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хууль, эрхийн актын талаарх 2 удаагийн сургалт,
- Архив, албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандартын талаарх 2 удаагийн ажлын байран дахь сургалт зэрэг болно.

6.4.4. Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт:

- Төрийн албаны төв зөвлөл болон аймгийн салбар зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан төрийн албан хаагчийн ёс зүйн болон чанарын удирдлагын стандартын сургалтад төрийн тусгай 10 албан хаагч,
- ММНБИ-ээс зохион байгуулсан эрх сунгах цахим сургалтад аудитор Ж.Цогт хамрагдаж, 2 шалгалтын дунджаар 78.0 хувийн гүйцэтгэлтэй шалгагдав.
- ММНБИ-ээс зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох цахим сургалтад аудитор О.Анхбаяр хамрагдаж, суурь 2 шалгалтыг

амжилттай өгч /нийт 5 шалгалтаас өмнөх онд 3 шалгалтад тэнцсэн байсан/, цаашид бусад шалгалтыг өгөх эрхтэй болов.

- ММНБИ-ийн Аудитын хорооноос зохион байгуулсан аудиторын эрх олгох сургалтад 4 албан хаагч хамрагдаж, “Аудиторын батламж” авав.
- Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төвөөс зохион байгуулсан “Худалдан авах ажиллагаагаар мэргэшүүлэх, “А” сертификат олгох сургалтад 4 албан хаагч хамрагдаж, шалгалтад тэнцэн “А” сертификат авав.
- Архивын ерөнхий газраас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт”, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам” сэдэвт сургалтад нууц хариуцсан аудитор болон архив, бичиг хэрэг хариуцсан гэрээт ажилтан нар хамрагдав.



6.5 Архив, албан бичиг хөтлөлт, албаны нууц:


Албан хэрэг хөтлөлт, бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд тус газрын дарга, тэргүүлэх аудиторын 35 тушаал гарч, явсан бичиг 183, ирсэн бичиг 85 тус тус бүртгэгдсэн бөгөөд үүнээс 39 хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэн, хүргүүлсэн байна.

Удирдлагын зөвлөлийн 12, хамт олны 5 хурлын тэмдэглэл хөтлөгдөн бүртгэгдсэн бөгөөд байгууллагын хэвлэмэл хуудсуудыг МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан индексийн дагуу дугаарлан бүртгэлээр хяналт тавьж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон нийтлэг журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан Архивын ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж, шинэчлэгдэн батлагдсан хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Байгууллагын баримт нягтлан шалгах комисс /БНШК/-ыг шинэчлэн байгуулж, ажиллах дүрмийг батлав.
- Албан хаагчдаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын саналыг авч нэгтгэн, БНШК-ын хурлаар баталгаажуулав.
- 2020-2021 оны баримт бичгийг ангилан төрөлжүүлж, байгууллагын архивт нийт 144 баримт хүлээн авсан.
- Дарга тэргүүлэх аудиторын 2016-2020 оны тушаалуудыг скайнердан, цахим хэлбэрт шилжүүлээд байна.



- Түр хадгалах хугацаа дууссан 1995-2017 оны нийт 88 хадгаламжийн нэгжийг аймгийн Төрийн архивын газрын БНШК-ын зөвшөөрлөөр устгалд оруулав.
- Байнга хадгалах 2010 он хүртэлх баримтыг төрийн архивт хүлээлгэн өгснөөр тус байгууллагын архивт нийт 984 хадгаламжийн нэгж байна.

Тус газар нь нууцын зэрэглэлд багтдаг Хилийн цэргийн 0101, 0243 дугаар ангиудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэдэг учир эдгээр байгууллагатай харьцсан ирсэн, явсан бичиг, жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг нууцын албан тоотоор хүлээн авч, хүргүүлэн Төрийн нууцын ирсэн бичгийн дэвтэрт бүртгэлээ.

Нууцад хамаарах баримт материалыг нууцын сейфэнд хадгалж, интернэт болон дотоод сүлжээнд холбогдох боломжгүй зөөврийн компьютероор бэлдэн гаргаж байгаа бөгөөд нууцтай холбогдон хөтлөгдөх 12 төрлийн бүртгэлийг тухай бүр бүртгэж байна.

Тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн аудиттай холбогдуулан 3 албан хаагч “Нууцын баталгаа” гаргаж аймгийн Тагнуулын газарт хүргүүлэв.

ТЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь газраас төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хийгдсэн хяналт шалгалтад 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хамрагдаж, амжилттай дүгнэгдлээ.

6.6 Хүний нөөц, шагнал урамшуулал, сахилгын шийтгэл, нийгмийн асуудлын шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн орон тооны 12 ажилтны 50.0 хувь нь тус газарт 5-аас дээш жил ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Ерөнхий аудиторов тушаалаар 1 аудитор томилогдож, 2 аудитор төрийн аудитын байгууллагын ажилтны тангараг өргөлөө.

Нийт албан хаагчдын 63.6 хувь нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй, 63.6 хувь нь магистр цолтой, жолоочоос бусад бүх ажилтнууд эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэй болно.



Ардын хувьсгалын 100, төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 99-100 жилийн ойн хүрээнд 5 албан хаагчийг төрийн одон медаль, шагнал урамшилд тодорхойлон ҮАГ болон аймгийн ИТХ-д хүргүүлсэн бөгөөд нягтлан бодох бүртгэл, бичиг хэргийн ажилтан Б.Наранцэцэг “Санхүү, банкны тэргүүний ажилтан” цол тэмдгээр, аудитор О. Анхбаяр аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнагдсан байна.

Төрийн жинхэнэ албан хаагч 11 ажилтан гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагч 1 ажилтан хөдөлмөрийн гэрээ байгуулж, улирал бүр дүгнэн, тайлант хугацааны ажлын үр дүнгээр 4 албан хаагчид шинээр зэрэг дэв олгуулах, 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах мэдүүлэг, танилцуулгыг ҮАГ-т хүргүүлэн шийдвэрлүүлээ.

Шинэчлэн батлагдсан ёс зүйн дүрэм, нөлөөллийн мэдүүлэг гаргах журмыг аудитор бүр судлан, хэрэгжүүлж ёс зүйн зөрчилгүй ажилласан бөгөөд албан хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, нийт 29.0 сая төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгов.

Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд “Хөдөлмөрийн дотоод журам”-д заагдсан дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүлд 455.0 мянган төгрөгийн бэлэг, дурсгалын зүйл олгов.
- Батлагдсан төсвийн хүрээнд нийт 10,745.0 мянган төгрөгийн хоол, унааны хөнгөлөлт олгов.
- Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 3 албан хаагчийн судалгааг гаргаж, ҮАГ-т хүргүүлснээр “Хаврын тэргүүн сарын шинийн 1” болон “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан тус бүр 100.0 мянган төгрөгийн, нийт 600.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.
- Шинээр хүүхэд төрүүлсэн ахлах аудитор Ц.Отгонбаярт хамт олны зүгээс 200.0 мянган төгрөгийн тусламж олгов.
- 2 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлтөд 600.0 мянган төгрөг олгов.
- Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд албан хаагчдыг амны хаалт, нэг удаагийн бээлий, гар ариутгагч, ажлын ачаалал ихтэй үед халуун аарц, жимсний шүүсээр хангах арга хэмжээ авч, өрөө тасалгааг тогтмол ариутган, халдваргүйжүүлж, батлагдсан төсвөөс 530.0 мянган төгрөгийг зарцуулаад байна.
- Ковид-19 өвчнөөр өвчилсөн 8 албан хаагчид хамт олны зүгээс тус бүр 200.0 мянган төгрөг, нийт 1,600.0 мянган төгрөгийн мөнгөн тусламж үзүүллээ.
- Энгийн галлагаатай орон сууцанд амьдардаг 2 аудиторт тус бүр 300.0 мянган төгрөг, нийт 600.0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгов.
- Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, шаардлагатай эмчилгээ, үйлчилгээ хийлгээд байна.

6.7 Төрийн хяналтын байгууллагын 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд хийсэн ажил:

Ирэх 2022 онд тохиож буй төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд нийт албан хаагчдаас хийх ажлын санал авч нэгтгэн, төлөвлөгөө боловсруулж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Төрийн аудитын байгууллагын эрхэм зорилго, чиг үүрэг, бүтэц, орон тоо болон Сэлэнгэ аймгийн үеийн төрийн хяналтын байгууллагын үүсэл, хөгжил, түүхэн замналаар цахим мэдээлэл, танилцуулга бэлтгэн audit.mn цахим хуудас болон байгууллагын фейсбүүк хуудсаар олон нийтэд мэдээлсэн.
- Төрийн хяналт, төрийн аудитын байгууллагад 1995 оноос өнөөг хүртэлх хугацаанд ажиллаж





байсан болон ажиллаж байгаа бүх хүмүүсийн судалгааг холбогдох үзүүлэлтүүдээр нэгтгэн гаргав.

- Үе үеийн ажилтнуудын төлөөлөл болох 5 хүний дурсамж, сэтгэгдлийг авч, ҮАГ-т хүргүүлэв.
- Хийж гүйцэтгэсэн хяналт шалгалт, аудитын тоо, илрүүлсэн алдаа, зөрчил зэрэг үндсэн үзүүлэлтүүдийн судалгааг нэгтгэн гаргав.
- Аймгийн төрийн хяналт болон аудитын байгууллагын түүхэн хөгжлийг гэрэл зургаар илэрхийлэн гаргах зорилгоор үе үеийн ажилтнууд, хамт олны гэрэл зургийг цуглуулан, цомог, самбар гаргах бэлтгэл ажлыг хангаад байна.

ДОЛОО. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус газрын 2021 оны үйл ажиллагаанд 518.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас урьдчилсан гүйцэтгэлээр 452.8 сая төгрөгийг зарцуулж, 87.4 хувийн гүйцэтгэлтэй, өр төлбөр, авлагагүй тайлагнагдсан ба цалин хөлсний зардал 57.0 сая төгрөгөөр, НДШ-ийн зардал 8.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдэж байна.

НДШ-ийн тайланг сар бүр, ХХОАТ-ын тайланг улирлаар гарган, холбогдох байгууллагуудад хүргүүлж, нийгмийн даатгалын шимтгэл, татварын өр, авлагагүй тайлагнагдсан.

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайлан, 2022-2023 оны төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдлийг холбогдох маягт, аргачлалын дагуу гаргаж тус тус тогтоосон хугацаанд нь ҮАГ-ын СХОГ-т хүргүүллээ.

2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд гарган, “Мишээл од” компаниар аудит хийлгүүлж, “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

2021 оны хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж тус газрын 2021 оны 98 дугаар албан бичгээр СХОГ-т хүргүүлсэн бол 1 болон 3 дугаар улирлын тайланг хуулийн хугацаанд нь Э-тайлангийн системд шивж оруулав.

ТӨБЗГ-аас төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2020 оны биелэлтийг 94 хувьтай дүгнэж, 2021 оны төрийн өмчийг эзэмшүүлэх 2021/СЭА/17-0344 дугаар гэрээг байгууллаа.

Байгууллагын 2021 оны эхний хагас, жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахтай холбогдуулж, дарга, тэргүүлэх аудиторовын 2021 оны А/07, А/18 дугаар тушаалуудаар томилогдсон “Эд хөрөнгийн тооллогын комисс” хөрөнгийн тооллого хийж, эд хөрөнгө эзэмшүүлэх картыг шинэчлэн хөтлөв.



Тайлант хугацаанд батлагдсан төсвийн хүрээнд 6.4 сая төгрөгийн шатахуун, 3.0 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж зэргийг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн бөгөөд шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авах ажиллагаа хийгдээгүй байна.

Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн удирдлагад хүсэлт гарган 20.0 сая төгрөгийн эх үүсвэрийг шийдүүлснээр архивын шүүгээ 4, албан хаагчдын ширээ 10, бичиг хэргийн шүүгээ 8, агааржуулагч 2 ширхэг болон дарга тэргүүлэх аудиторов өрөөний иж бүрэн тавилгыг худалдан авч шинэчиллээ.



НАЙМ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Үндсэн чиг үүргийн 32 арга хэмжээний хэрэгжилтийг ханган, 298 санхүүгийн тайлан, 8 гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр тогтоосон акт 94.1 хувийн, албан шаардлага 89.6 хувийн, зөвлөмж 85.8 хувийн биелэлттэй тайлагнагдав.
- Үйл ажиллагааг дэмжих, дотоод чиг үүргийн зорилтын хүрээнд төлөвлөсөн 12 ажил, үйлчилгээг бүрэн хэрэгжүүлэв.

ЕС. ХАВСРАЛТУУД

Тус газрын 2021 оны үйл ажиллагааны тайланд дараах мэдээ, тайлан, судалгааг хавсаргав. Үүнд:

- 2021 оны жилийн эцсийн статистик мэдээ,
- Аудитаас бий болсон үр өгөөжийн тайлангийн нэгтгэлийг хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөжийн нэгтгэлийн маягтаар гаргасан судалгаа,
- Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагын хэрэгжилтийн дэлгэрэнгүй судалгаа зэрэг болно.

ТАЙЛАН ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ





СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

📍 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар
/Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын байр, өргөтгөл/

✉ selenge@audit.gov.mn



www.audit.mn



(+976)7036-3040

(+976)7036-3036

(+976)7036-2442